



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2021/06

САЙНШАНД ХОТ

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1--15
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	16
Нэг. Эрүүл мэнд.....	17-18
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	19-21
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	22-25
Дөрөв. Гэмт хэрэг.....	26-27
Тав. Мөнгө,зээл	28-29
Зургаа. Төсөв, санхүү	30-31
Долоо. Үнэ.....	32-35
Найм. Хөдөө аж ахуй	36-38
Ес. Аж үйлдвэр.....	39-43
Арав. Тээвэр	44
Арван нэг. Байгаль орчин	45



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2021 оны 06 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2021 оны 06 сард 736 эх амаржиж, 743 хүүхэд шинээр мэндэлж, 169 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 52(7.6%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 55(8.0%)-аар, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 4(2.4%)-өөр тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 574 болж 2020 оны мөн үеийнхээс 51(9.8%)-ээр өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 10.6, нас баралт 2.4 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.8 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2018-2021 оны 06 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар буурчээ.



1.2 Эрүүл мэнд

2021 оны эхний 06 сарын байдлаар 236.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар, 6.0 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар тус тус өсч, 8.2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар буурчээ.




2021 оны эхний 06 сард 854 эх жирэмсний хяналтанд орсны 93.2 хувь буюу 796 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.6 пунктээр буурсан байна.

Түргэн тусламжийн дуудлага 9.1 мянган удаа гарсны 1.5 мянга буюу 16.5 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар, алсын дуудлага 16.7 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 1234 хүн бэртэж, 26 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 209(14.5%)-өөр буурч, нас барсан хүний тоо 1(4.0)-ээр өссөн байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2021 оны 05 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 32.5 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 24.9 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 15.4 хувь, бусад төрлийн өвчин 13.0 хувь, , хоол шингээх эрхтний өвчин 7.7 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 6.5 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 256 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 88-аар буюу 31.4 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад цусан суулга 75.8 хувиар, тэмбүү 59.1 хувиар, трихоминиаз 43.5 хувиар, сүрьеэ 32.4 хувиар, заг хүйтэн 29.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 06 сарын эцэст 567 болсны 349 (61.6%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 218 (38.4%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 118(26.3%) хүнээр, өмнөх сараас 284 (100.3%) хүнээр илүү байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 311(54.9%) нь бүрэн дунд, 124(21.9%) нь дээд, 64(11.3%) нь тусгай дунд, 26(4.6%) нь техник мэргэжлийн, 26(4.6%) нь бүрэн бус дунд, 7(1.2%) нь боловсролгүй, 5(0.9%) нь бага, 4(0.7%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2021 оны 06 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2021 оны эхний 06 сарын байдлаар бүртгэлтэй байсан 183 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 35 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.




1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 06 сарын байдлаар 26305.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5178.2 (24.5%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 06 сард өмнөх оны мөн үеэс 5178.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 5288.4 (39.9%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 59.7 (4.0%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 808.1 (23.0%) сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.




Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2021 оны 06 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 31494.8 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 1817.8 (6.1%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 23343.0 (74.1%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4269.0 (13.6%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 1797.9 (5.7%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1436.6 (4.6%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 648.3 (2.1%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг





Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 06 сард нийгмийн халамжийн сангаас 10566 иргэнд 2417.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан иргэд 11411 (51.9%)-оор, олгосон тэтгэвэр тэтгэмж 2015.6 (45.5%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт буурсан нь 2020 оны 09-р сараас эхлэн цалинтай ээж хөтөлбөр, жирэмсэн эхийн тэтгэмж, алдарт эхийн одонгийн тусламж, насны хишиг, ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжүүд и-халамж цахим системд шилжиж ХХҮЕГ-аас шууд арилжааны банкууд шилжүүлэг хийгддэг болсонтой холбоотой юм.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны 06 сард 1304 хүн хамрагдсан нь өмнөх оноос 30 (2.2%)-аар, олгосон тэтгэвэрийн хэмжээ 972.2 сая төгрөг болж 684.6 (41.3%) сая төгрөгөөр тус тус буурчээ.


Нийгмийн халамжийн тэтгэмж 1145 иргэнд 593.5 сая төгрөг, амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1037 иргэнд 510.7 сая төгрөг болон нийгмийн халамжийн сангийн зардлыг 28 иргэнд 34.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 7052 иргэн хамрагдаж, 304.9 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2021 оны 06 дугаар сарын байдлаар 216 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 94 хүн гэмтэж, 3 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 12(5.3%)-оор, нас барсан хүний тоо 5 (62.5%)-аар тус тус буурч, гэмтсэн хүний тоо 36 (62.1%) –аар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 44 (2.1 дахин)-өөр, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2 (20%)-оор, тус тус өсч, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 7(63.6%)-оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7(63.6%)-оор, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 3(60.0%)-аар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 30(24.0%)-аар, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1(16.7%)-ээр тус тус буурч, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 44.0 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 38.4 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 5.6 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2.8 хувийг олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 2.3 хувийг нийтийн шиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 1.9 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.0 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 51 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11(27.5%)-ээр нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Иххэт, Мандах, Хатанбулаг, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Хөвсгөл суманд өмнө оны мөн үеийнхтэй адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.




Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 298.8 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7210.0 (96.0%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 166.7 (55.8%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 90(41.7%) нь гэр орон сууцандаа, 51(23.6%) нь согтуугаар, 31(14.4%) нь гудамж олон нийтийн газарт, 11(5.1%) бүлэглэн, 19(8.8%) хувийг эмэгтэй хүн оролцон, 69(31.9%) нь өдрийн цагаар /14-19 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 601 хүн саатуулагдаж, 109 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2021 оны 06 сард





Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк


Монгол банкны 6-р сарын мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 33.8 мянга болж өмнөх оноос 1.3(3.7%) мянган хүнээр буурч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 77.3 мянга болж өмнөх оны мөн үеээс 8.6 хувиар өссөн байна.

Ипотекийн нийт зээлдэгчийн тоо 124 болж өмнөх оны мөн үеэс 76(2.5²) өсч, нийт олгосон зээлийн хэмжээ 6995.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 5010.3(3.5²) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2020-2021 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2020- 2021 он, мян.хүн



Нийт хадгаламжийн үлдэгдэл 199.9 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 2586.9 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 2800.7 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66.0(49.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.




Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 6.8 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 726.9(9.6%) сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 326.2(4.5 %) сая төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 12.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 39.2(1.1%)сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 8805.1(76.3%) сая төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 3.7 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл, төрлөөр, тэрбум төгрөг, 2021.06 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2021.06 сард






2.2 Төсөв, санхүү

2021 оны 06 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 14844.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 79.0 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 13.7 хувиар буурсан байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 89.6 хувийг татварын, 7.4 хувийг татварын бус орлого, 3.0 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2021 оны 06 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 4588.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 6.2 хувь буюу 302.4 сая.төг-өөр дутуу, төлөвлөгөөнөөс 14.6 хувь буюу 584.4 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 06 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 1.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.3 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 2.9 хувь, согтууруулах бус ундааны бүлэг 0.3 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 0.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.2 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.5 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.6 хувь, тээврийн бүлэг 0.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний




бүлэг 2.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 4.1 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 0.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.1 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 15.1 хувь, согтууруулах бус ундааны бүлэг 1.7 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 4.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 1.5 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 6.7 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 10.0 хувь, тээврийн бүлэг 2.9 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 2.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 10.9 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 3.1 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2021 оны 05 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)




Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020-2021 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)





Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017-2021 оны 06 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1083.4 мянган хээлтэгч малын 712.1 мянга (65.7%) нь 2021 оны эхний 06 сард төллөсөн байна. Эм хонины 73.7 хувь, эм ямааны 62.4 хувь, үнээний 50.1 хувь, гүүний 44.6 хувь, ингэний 42.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 97.4 хувь буюу 694.9 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 37.9 (5.2%) мянгаар бага байна. Дэлгэрэх суманд 77.9 мянга, Хатанбулаг 74.7, Иххэт суманд 67.1 мянга, мянга, Алтанширээ суманд 62.1 мянга, Даланжаргалан суманд 59.3, Айраг суманд 50.0 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 56.3 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 06 сард аймгийн хэмжээнд 28368 болж, өмнөх оны мөн үеэс 27474 (31 дахин) толгойгоор илүү байна. Нийт хорогдсон малын 53.9 хувийг ямаа, 37.1 хувийг хонь эзэлж байна.


Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 06 сард





Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Хөвсгөл суманд хамгийн их буюу 1550.0 мянган төгрөг, Эрдэнэ суманд хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1300.0 мянган төгрөг, Сайхандулаан, Эрдэнэ, Замын-үүд сумдад хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг, хязаалан гуна Өргөн суманд хамгийн их буюу 1600.0 мянган төгрөг, Замын-үүд суманд хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Даланжаргалан, Хатанбулаг сумдад хамгийн их буюу 280.0 мянган төгрөг, Улаанбадрах суманд хамгийн бага буюу 170.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Хатанбулаг, Хөвсгөл сумдад хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 90.0 мянган төгрөг байна.

Зураг. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 06 сард, мянган төгрөгөөр



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 06 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 127628.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 300097.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 63138.9 сая төгрөгөөр буюу 97.9 хувиар, нийт борлуулалт 176322.1 сая төгрөгөөр буюу 2.4 дахин өссөн байна.

2021 оны 06 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт бүх салбарт өсжээ. Үүнд өмнөх оноос уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт 55744.0 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 7162.0 сая төгрөгөөр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбар 10.8 сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 222.2 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 4.6 хувийг төрийн, 95.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 4.6 хувь, компани 94.9 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 17.7 мян.кв.цагаар, ус түгээлт 43.9 мян.м3-аар, сувагжуулалт 58.2 мян.м3-аар, савласан цэвэр ус 793.8 мян.литрээр, бялуу 1.7 тонноор, хиам 13.2 тонноор, банш, бууз 3.7 тонноор, гутал 79 ширхгээр, нүүрс 795.1 мян.тонноор, шохой 5450 тонноор, цемент 104.1 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.



3.3 Тээвэр

2021 оны 6-р сарын байдлаар 323.3 мянган тонн ачаа тээвэрлэж, 57571.4 мянган тонн км-ын ажил, 7.5 мянган зорчигч тээвэрлэж, 3276.5 мянган хүн,км-ын ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 31009.1 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 56.6 хувиар буурсан байна.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: 6-р сарын дундаж агаарын температур нийт нутгаар 18.6 – 23.2 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 33 - 37 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД /-тай харьцуулахад: Иххэт, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдын нутгаар ОЖД-аас дулаан. Бусад сумдын нутгаар ОЖДундаж орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө -1.0 градусаас 3.0 градус дулаан, өдөртөө нийт нутгаар 59 - 66 градус дулаан байв.

Хур тунадас: Энэ сард нийт нутгаар бороо 4 - 13 өдөр бороотой байлаа. Сайншанд суманд 17.1 мм, Замын-Үүд суманд 12.8 мм, Мандах суманд 9.9 мм, Хөвсгөл суманд 6.5 мм, Дэлгэрэх суманд 33.9 мм, Эрдэнэ суманд 28.8 мм, Айраг суманд 22.8 мм, Алтанширээ суманд 15.2 мм, Иххэт суманд 65.1 мм, Өргөн суманд 31.2 мм, Сайхандулаан суманд 21.8 мм, Улаанбадрах суманд 22.8 мм, Хатанбулаг суманд 6.9 мм дуу цахилгаантай аадар бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад ОЖД-аас бага, Сайншанд, Алтанширээ суманд ОЖДундаж орчим. Бусад сумлын нутгаар ОЖД-аас ахиу бороо орсон байна.



Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Иххэт, Алтанширээ, Сайхандулаан суманд 10 - 14 м/с, бусад сумдын нутгаар 17 – 24 м/с хүрч, нөөлөг салхи ажиглагдаж, цаг агаарын аюултай үзэгдэл ажиглагдсан. 10 м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Алтанширээ, Иххэт, Сайхандулаан Айраг, Өргөн Хатанбулаг, Улаанбарах сумдад 1 - 15 өдөр, бусад сумдад 20 – 23 өдөр салхи ихтэй, цаг агаар тогтворгүй байлаа.

Бэлчээрийн ургамал: Энэ сарын байдлаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр нийт нутгаар 4 - 11 см байна. Нийт сумдын нутгаар нийт ургамал, төлөөлөх бэлчээрийн ургамал цухуйсан. Хөвсгөл сумын нутгаар бэлчээрийн төлөөлөх ургамал цухуйгаагүй байна.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй ч халуун хуурай салхи ихтэй байна. Малд нэмэгдэл тэжээл өгөх, хөөвөр ноос авах ажиллагаа явагдаж байна. Нийт нутгаар малын усан хангамж дунд зэрэг байна.

_____ о О о _____



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2021 2020
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	69.6	69.9	71.2	71.8	100.8
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	666	625	688	743	108.0
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	191	188	165	169	102.4
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	475	437	523	574	109.8
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	1	2	9	6	66.7
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	1.5	3.2	13.1	8.1	61.7
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	696	657	449	567	126.3
- Үүнээс эмэгтэй	тоо	353	356	221	257	116.3
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	161	152	105	131	125.0
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	122	51	130	224	172.3
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	70	19	85	75	88.2
Улирлын чанартай ажлын байр	тоо	52	32	3	5	166.7
Түр ажлын байр	тоо				144	
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	147	196	373	256	68.6
- 10000 хүнд ногдох	тоо	21	28	53	36	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	293	298	228	216	94.7
- 10000 хүнд ногдох ***	тоо	68	67	53	50	
6.Бойжиж буй төл	толгой	591946	679524	732820	694896	94.8
- Унага	толгой	19003	18663	23633	24283	102.8
- Тугал	толгой	15858	14566	20497	20313	99.1
- Ботго	толгой	6512	6953	7927	7688	97.0
- Хурга	толгой	292632	339672	364724	346824	95.1
- Ишиг	толгой	257941	299670	316039	295788	93.6
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	101390.1	95114.6	64489.7	127628.6	197.9
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	133430.9	165682.6	123775.4	300097.5	2.4 ²

* - 2018,2019,2020 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2020 I-VI	2021 I-VI	Өсөлт	
		тоо			хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	199.6	236.3	36.7	118.4
2. Ор хоног	мян.хүн	64.4	60.1	-4.3	93.3
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	5.8	6.0	0.2	103.4
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	9.2	8.2	-1.0	89.1
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	10.2	9.1	-1.1	89.2
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.8	1.5	-0.3	83.3
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1443	1234	-209.0	85.5
Үүнээс: нас баралт	хүн	25	26	1.0	104.0
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	899	854	-45.0	95.0
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	815	796	-19.0	97.7
8. Амаржсан эх	хүн	684	736	52.0	107.6
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0.0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	0	0.0	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	9	6	-3.0	66.7

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 06 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	
	тоо				
Дүн	736	0	743	6	0
Айраг	1		1		
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх	2		2		
Иххэт	2		2		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан	1		1		
Улаанбадрах					
Хатанбулаг	3		3		
Хөвсгөл	1		1		
Эрдэнэ					
Сайншанд	551		556	4	
Замын - Үүд	175		177	2	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 06 сард

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	Өсөлт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	373	256	-88	68.6
Вируст гепатит	3	0	-3	0.0
Сүрьеэ	37	25	-9	67.6
Тэмбүү	88	36	-52	40.9
Заг хүйтэн	112	79	-33	70.5
Трихоминиаз	46	26	-20	56.5
Цусан суулга	33	8	-25	24.2
Бусад	54	82	28	151.9

Тайлбар -2-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 06 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2018 VI	2019 VI	2020 VI	2021 VI	2021 VI 2018 VI	2021 VI 2020 VI
	хүний тоо				хувь	
ДҮН	926	765	449	567	61.2	126.3
Үүнээс: Эмэгтэй	436	373	211	257	58.9	121.8
Магистр, доктор	1	3	1	4	400.0	0.0
Дээд боловсролтой	168	87	95	124	73.8	130.5
Тусгай дунд	40	26	44	64	160.0	145.5
Техник мэргэжлийн	57	30	27	26	45.6	96.3
Бүрэн дунд	575	542	223	311	54.1	139.5
Бүрэн бус дунд	56	51	47	26	46.4	55.3
Бага	6	3	5	5	83.3	100.0
Боловсролгүй	23	23	7	7	30.4	100.0

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 06 сарын эцэст

	Бүртгэлтэй иргэдийн тоо		Ажилд орсон иргэдийн тоо		Шинээр нэмэгдсэн иргэдийн тоо	
	2020 VI	2021 VI	2020 VI	2021 VI	2020 VI	2021 VI
ДҮН	449	567	530	358	1192	1016
Айраг	17	13	2	1	30	12
Алтанширээ	5	18	3	8	14	26
Даланжаргалан	6	15	0	0	8	14
Дэлгэрэх	3	1	0	0	9	2
Иххэт	3	0	3	0	10	0
Мандах	20	5	0	3	24	9
Өргөн	13	20	1	37	16	57
Сайхандулаан	9	6	2	1	6	8
Улаанбадрах	6	3	1	10	17	7
Хатанбулаг	16	13	31	31	54	44
Хөвсгөл	8	2	0	0	9	1
Эрдэнэ	34	18	7	32	44	64
Сайншанд	171	285	106	106	444	449
Замын - Үүд	138	168	374	129	507	323

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, жил бүрийн 06 сарын эцэст

Салбарын ангилал	2020 I-VI	2021 I-VI
	Тоо	
Бүгд	771	452
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	7	0
Уул уурхай олборлох аж үйлдвэр	4	49
Боловсруулах үйлдвэрлэл	1	4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	17	2
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент	41	4
Барилга	115	108
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар	24	18
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	9	9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	7	1
Мэдээлэл, холбоо	0	0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	354	109
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын	46	12
Боловсрол	23	9
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	27	28
Урлаг, үзвэр,тоглоом наадам	15	8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	79	83
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн	0	0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, жил бүрийн 06 сарын эцэст

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI
	Тоо	
Бүгд	771	452
Менежер	5	11
	438	174
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	32	35
Контор, үйлчилгээний ажилтан	15	11
Худалдаа, үйлчилгээний ажилтан	56	23
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	41	105
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	32	8
Энгийн ажил мэргэжил	105	82
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	47	3

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 06 сарын эцэст

Үзүүлэлт	2020 I-VI		2021 I-VI	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	530	322	358	187
Менежер	1	1	9	7
Мэргэжилтэн	367	264	166	109
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	15	10	25	18
Контор, үйлчилгээний ажилтан	9	6	9	8
Худалдаа, үйлчилгээний ажилтан	33	18	15	12
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0	0	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	26	10	78	20
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч,	22	0	7	0
Энгийн ажил мэргэжил	55	13	47	12
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	2	0	2	1

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2021 оны 06 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	Тоо				
Бүгд	224	124	75	5	144
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0				
Уул уурхай олборлолт	1	1		1	
Боловсруулах үйлдвэрлэл	3		3		
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	0				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	0				
Барилга	15	3	3	3	9
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны	24	12	23	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	12	1	12		
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2	2	2		
Мэдээлэл холбоо	0				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5	3	5		
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл	16	4	8		8
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	96	64	8		88
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын	29	22	3		26
Боловсрол	4	3	4		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1	1			1
Урлаг үзвэр тоглоом наадам	1		1		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	15	8	3		12
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0				

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 06 сарын эцэст

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	2021 I-VI 2020 I-VI
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	21 127.6	26 305.8	124.5
Тэтгэврийн даатгалын сан	13268.6	18 557.0	139.9
Тэтгэмжийн даатгалын сан	1506.3	1 566.0	104.0
Эрүүл мэндийн даатгалын сан	3515.3	4 323.4	123.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2215.4	1 551.2	70.0
Ажилгүйдлийн даатгалын сан	622.0	308.2	49.5
Нийгмийн даатгалын сангийн зарлага	29 677.0	31 494.8	106.1
Тэтгэврийн даатгалын сан	21716.6	23 343.0	107.5
Тэтгэмжийн даатгалын сан	1886.9	1 797.9	95.3
Эрүүл мэндийн даатгалын сан	3805.9	4 269.0	112.2
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1452.0	1 436.6	98.9
Ажилгүйдлийн даатгалын сан	815.6	648.3	79.5

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 06 сарын эцэст

Үзүүлэлт	2020 I-VI	2021 I-VI	2021 I-VI 2020 I-VI
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	20531	19670	95.8
Албан журмаар даатгуулагчид	16957	16679	98.4
Аж ахуй нэгж, байгууллага	8821	8641	98.0
Төсөвт байгууллага	8136	8038	98.8
Сайн дураар даатгуулагчид	3574	2991	83.7
2. Тэтгэвэр авагчдын тоо	9110	9480	104.1
Өндөр насны тэтгэвэр	6640	6984	105.2
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1329	1382	104.0
Тэжээгчээ алдсаны	492	473	96.1
Цэргийн тэтгэвэр	478	497	104.0
ҮОМШӨ*-ний	171	144	84.2
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	22 922.8	23 777.5	103.7
Өндөр насны тэтгэвэр	16 020.0	17 504.3	109.3
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2 532.3	2 743.9	108.4
Тэжээгчээ алдсаны	996.5	1 046.7	105.0
Цэргийн тэтгэвэр	1 922.0	2 040.8	106.2
ҮОМШӨ*-ний	1 452.0	441.8	30.4

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2020 I-VI	2021 I-VI	2021 I-VI 2020 I-VI
	сая төгрөг		хувь
ДҮН	21127.6	26305.8	124.5
Айраг	333.7	386.5	115.8
Алтанширээ	150.3	172.9	115.0
Даланжаргалан	908.9	919.0	101.1
Дэлгэрэх	165.2	198.0	119.9
Иххэт	253.7	374.7	147.7
Мандах	165.6	200.0	120.8
Өргөн	379.1	648.7	171.1
Сайхандулаан	160.4	186.2	116.1
Улаанбадрах	186.2	218.6	117.4
Хатанбулаг	382.4	480.2	125.6
Хөвсгөл	174.1	207.6	119.2
Эрдэнэ	338.8	361.9	106.8
Сайншанд	12110	14954.6	123.5
Зүүнбаян баг	625.9	691.2	110.4
Замын-Үүд	4793.3	6305.7	131.6

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2020 I-VI	2021 I-VI	2021 I-VI 2020 I-VI
	сая төгрөг		хувь
ДҮН	29677.0	31494.8	106.1
Айраг	1394.1	1445.3	103.7
Алтанширээ	542.1	578.5	106.7
Даланжаргалан	1244.5	1226.6	98.6
Дэлгэрэх	633.5	689.4	108.8
Иххэт	987.3	1039.8	105.3
Мандах	628.2	660.8	105.2
Өргөн	904.5	969.8	107.2
Сайхандулаан	451.4	491.0	108.8
Улаанбадрах	631.6	715.2	113.2
Хатанбулаг	1095.6	1155.0	105.4
Хөвсгөл	541.7	577.5	106.6
Эрдэнэ	989.1	1079.3	109.1
Сайншанд	13100.0	13611.2	103.9
Зүүнбаян баг	1056.1	1065.1	100.9
Замын-Үүд	5477.3	6190.3	113.0



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 06 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-VI 2020 I-VI	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-VI 2020 I-VI
	2020 I-VI	2021 I-VI		2020 I-VI	2021 I-VI	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	21977	10566	48.1	4432.7	2417.1	54.5
1. Халамжийн тэтгэвэр	1334	1304	97.8	1656.8	972.2	58.7
Ахмад настны тэтгэвэр	95	102	107.4	115.8	58.8	50.8
Хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан ХБИ	378	357	94.4	446.8	204.4	45.7
Хөдөлмөрийн чадвараа 70%-с дээш алдсан ХБИ	469	467	99.6	579.3	268.9	46.4
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	1	100.0	1.3	0.6	43.8
Тэжээгч нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэвэр	391	377	96.4	513.5	439.6	85.6
2 Халамжийн тэтгэмж	1095	1145	104.6	545.0	593.5	108.9
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	542	544	100.4	238.4	253.3	106.2
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	234	255	109.0	162.5	179.2	110.3
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	259	291	112.4	114.1	131.1	114.9
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	45	88.2	25.7	24.8	96.4
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	5	4	80.0	2.3	2.0	87.6
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	4	6	150.0	1.9	3.0	159.3
3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2021 I-V 2020 I-V	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2021 I-V 2020 I-V
	2020 I-V	2021 I-V		2020 I-V	2021 I-V	
	тоо		хувь	сая төгрөг	хувь	
4. Амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	950	1037	109.2	373.0	510.7	136.9
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	237	258	108.9	293.4	419.9	143.1
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	713	779	109.3	79.6	90.7	114.0
5. Нийгмийн халамжийн сан	29	28	96.6	34.8	34.8	100.0
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	4	2	0.0	4.8	2.4	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	23	25	108.7	27.6	31.2	113.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		1			1.2	
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	2		0.0	2.4		0.0
6. Бусад халамжийн дүн	18569	7052	38.0	1820.7	304.9	16.7
Жирэмсэн эхийн тэтгэмж	1167		0.0	23.3		0.0
